SARS-CoV-2 халдварын улмаас АШУҮИС-ийн төв эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгсдийн сэтгэцийн эрүүл мэндийн тусламжийн хэрэгцээг судалсан дүн

А.Монголжин[1,2], Э.Мөнх[1,2], Х.Алтайсайхан[3], З.Хишигсүрэн[1]

[1]АШУҮИС, АУС, Сэтгэцийн Эрүүл Мэндийн Тэнхим
[2]Сэтгэцийн Эрүүл Мэндийн Үндэсний Төв
[3]АШУҮИС, Төв эмнэлэг
Цахим шуудан: am.mongoljin@gmail.com, Утас: 80039666

Түлхүүр үг:

Цар тахал
Сэтгэцийн эрүүл мэнд
Хэрэгцээ
Тусламж үйлчилгээ

Товч утга:

Үндэслэл: SARS-CoV-2 халдвар дэлхий дахинаа эрчимтэй тархаж цар тахлын хэмжээнд хүрсэн нь хүн амд сэтгэцийн эрүүл мэндийн хэрэгцээ, тусламж үйлчилгээ хэчнээн чухал болохыг илүүтэй ойлгох, мэдрэх боломжийг нэмэгдүүлсэн. Өөрөөр хэлбэл цар тахал нь хүн амын сэтгэлзүй, сэтгэцийн эрүүл мэндийн сайн сайхан байдалд ноцтой сөрөг нөлөө үзүүлсэн. Ялангуяа SARS-CoV-2 халдвар батлагдан эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдэд халдварын алсын үр дагавраас айх, халдвар бусдад тараах, үхэхээс айх зэрэг айдас, нийгмийн ялгаварлан гадуурхалд өртөх, сэтгэл түгшилтийн шинжүүд илүүтэй илэрснээр сэтгэл гутрал, нойрны хямралд өртөж зарим тохиолдолд амиа егүүтгэх оролдлого хийх, амиа егүүтгэхэд ч хүрэх эрсдэлтэй болох талаар дурджээ. Иймд бид SARS-CoV-2 батлагдан АШУҮИС-ийн эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн тухайн үеийн сэтгэцийн эрүүл мэндийн зарим байдал, сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хэрэгцээг зайлшгүй судлах шаардлагатай гэж үзлээ. **Зорилго:** SARS-CoV-2 халдварын улмаас эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн тухайн үеийн сэтгэцийн эрүүл мэндийн зарим байдал, сэтгэцийн эрүүл мэндийн тусламжийн хэрэгцээг судлан тогтооход оршино. **Арга, аргачлал:** Судалгааг дискрептив судалгааны эмнэлэгт суурилсан агшингийн загвараар, асуумж судалгааны аргаар хийж гүйцэтгэв. Судалгаанд 2021 оны 5-8-р сард АШУҮИС-ийн төв эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн 399 эмчлүүлэгчийг сайн дурын үндсэн дээр хамруулав. Статистик боловсруулалтыг STATA 15.1 программаар тооцоолсон. **Үр дүн:** Бидний судалгаанд 18-85 насны 399 эмчлүүлэгч хамрагдсан ба дундаж нас нь 40.5±0.7 жил байв. Судалгаанд хамрагдагсдын 56% нь эмэгтэй (n=224), хүйсийн харьцаа 1.28:1 байв. Эмчлүүлэгсэд нь судалгаанд хамрагдах үедээ эмчилгээний 1-12 дахь хоногтоо эмчлүүлж байсан ба дундаж ор хоног 8.4±0.9 байв. Судалгааны үр дүнгээс үзвэл 52.4% (n=209) нь сэтгэл гутрал, 80% (n=318) нь сэтгэл түгшилттэй, 49%-д (n=194) нойрны хямрал илэрсэн ба 6%-д (n=24) нь гэмтлийн дараах стрессийн эмгэг, 98% (n=392) нь нийгмийн ялгаварлан гадуурхалд, 97.5% (n=389) нь өөрийгөө ялгаварлан гадуурхах байдалд өртсөн байв. Ялгаварлан гадуурхалтын түвшинг үнэлэх сорилын найдвартай байдлыг Кронбахын коэффициентоор тооцож үзэхэд нийгмийн ялгаварлан гадуурхалтыг үнэлэх сорил α=0.90, өөрийгөө ялгаварлан гадуурхах байдлыг үнэлэх сорилынх α=0.89 байв. Судалгаанд хамрагдагсдаас “Ковид өвчнөөр өвчилсөн хүмүүст сэтгэцийн эрүүл мэндийн зөвлөгөө, дэмжлэг хэрэгтэй юу?” гэсэн асуултанд дийлэнх хувь нь буюу 69% (n=276) нь хэрэгтэй гэж хариулсан байна. Сэтгэцийн эрүүл мэндийн тулгамдсан асуудал илэрсэн эмчлүүлэгчдийн дийлэнх хувь нь ковид өвчнөөр өвчилсөн хүмүүст сэтгэцийн эрүүл мэндийн зөвлөгөө, дэмжлэг хэрэгтэй гэж үзэж байгаа боловч бусад бүлгүүдтэй харьцуулахад статистик ач холбогдол бүхий ялгаа ажиглагдсангүй. Судалгаанд ашигласан хувь хүний сэтгэлзүйн хэв шинжийг тодорхойлох-EPI сорилын найдвартай байдлыг судлан үзэхэд α=0.81 байв. **Дүгнэлт:** Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн олонх нь сэтгэл гутрал, сэтгэл түгшил, нойрны хямралтай, нийгмийн болон өөрийгөө ялгаварлан гадуурхах зэрэг сэтгэцийн эрүүл мэндийн тулгамдсан байдалтай, асуумжаар 69% нь тусламж хэрэгтэй хэмээн хариулснаас үзвэл өвчлөгсдөд сэтгэцийн эрүүл мэндийн зөвлөгөө, дэмжлэг зайлшгүй хэрэгтэй байна.

Үндэслэл: Хүн төрөлхтний 12 000 жилийн түүхийн туршид тахал өвчний улмаас 300-500 сая орчим хүн нас барсан ба тухайлбал дундад зууны үед Европын хүн амын 60 орчим хувь нь нас барсан тахал ч гарч байсан байна. Анагаах ухаанд орчин үеийн дэвшил гарсан хэдий ч 2019 оны 12 дугаар сард Хятадын Ухань хотод илэрсэн коронавирусын халдварын (SARS-CoV-2) улмаас 3 жил хүрэхгүй хугацаанд 6 сая гаруй хүн нас бараад байна.[1] SARS-CoV-2 тахал нь хүний амь насанд заналхийлж, хувь хүний болон нийгмийн амьдралын бүхий л салбарт нөлөөлснөөр вирусын халдвар авсан болон халдваргүй аль ч хүмүүсийн сэтгэл зүйд сөргөөр нөлөөлсөн гэж үзэж болно. Цар тахлын эхэн үед уг вирусын хүний амь насанд аюултай шинж чанар нь бүрэн тодорхойгүй байсантай холбоотойгоор олон нийтэд айдас, сэтгэл түгшилт илүүтэй үүссэн учраас олон орны эрдэмтэн, судлаачид SARS-CoV-2-ийн үеийн хүн амын сэтгэцийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлыг судалсаар байна.[2]

Хэвлэлийн тоймоос үзвэл өвчний дэгдэлтийн үеэр БНХАУ-ын орон нутгийн эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байсан SARS-CoV-2 халдвартай өвчтөнүүдийн 43.9% нь сэтгэцийн тулгамдсан асуудалтай, нарийвчлан үзвэл 12.2%-д гэмтлийн дараах стрессийн эмгэгийн шинж илэрсэн, 26.8% нь сэтгэл түгшилт болон сэтгэл гутралын шинж тэмдэгтэй, 53.6% нь архаг ядаргаатай, хүн амын ялгаварлан гадуурхал өндөр түвшинд байх нь сэтгэцийн эрүүл мэндэд сөрөг нөлөө ихтэй, ялангуяа стрессийг даван туулах сөрөг хандлага нь сэтгэлийн гэмтлийн дараах стрессийн эмгэг үүсгэх эрсдэлтэй байжээ.[3,4]

Одоогоор SARS-CoV-2 халдварын үеийн хүн амын сэтгэцийн эрүүл мэндийн байдлыг хувь хүний авир араншинтай харьцуулсан судалгаа ховор, харин сэтгэлзүйн хэвшинжтэй холбон судалсан судалгаа байна. Тухайлбал АНУ-д SARS-CoV-2 халдварын үеийн нийгмийн хорио цээрийн дэглэмээс хойш 4-8 долоо хоногийн дараа сэтгэлийн шалтгаант архаг өвдөлттэй (n=150) хүмүүст хийсэн судалгаагаар сэтгэл зүйн хувьд гадагшаа хэвшинжтэй хүмүүс нь дотогшоо хэвшинжийн хүмүүсээс нойрны хямрал, сэтгэцийн бусад тулгамдсан асуудал багатай байна гэсэн дүгнэлтэнд хүрчээ.[5]

Түүнчлэн 47 улсад, 93125 хүн хамруулан хийсэн тойм судалгаагаар сэтгэлзүйн дотогшоо хэвшинжтэй хүмүүс SARS-CoV-2 халдварын хөл хорионы үед сэтгэлзүйн хямралд илүүтэй өртөж байсан бол гадагшаа чиглэсэн сэтгэлзүйн хэвшинжтэй хүмүүс цар тахлыг байгалийн үзэгдэл мэт хүлээн авч байсан гэсэн үр дүнд гарчээ.[6] 2020 оны 5-р сарын 25-аас 2020 оны 6-р сарын 25-ны хооронд Турк улсад эмнэлэгт хэвтэн эмчлүүлж буй SARS-CoV-2 халдвартай эмчлүүлэгчид, 14 хоногийн тусгаарлалтанд байгаа иргэд, гэрийн хорио цээрийн дэглэмд байгаа хүмүүсийг харьцуулан судлахад тусгаарлагдсан иргэдийн сэтгэл түгшилтийн түвшин нь SARS-CoV-2 халдварын улмаас эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгсдийнхээс мэдэгдэхүйц бага түвшинд байгаа нь статистикийн хувьд ач холбогдол бүхий хамааралтай байжээ (p=0.0001).[7]

Бид энэ удаагийн судалгаагаар эмнэлэгт хэвтэн эмчлүүлж буй SARS-CoV-2 халдвар батлагдсан эмчлүүлэгчдийн тухайн үеийн сэтгэцийн эрүүл мэндийн байдал, хувь хүний авир араншин, сэтгэцийн эрүүл мэндийн тусламжийн хэрэгцээг судлах шаардлагатай гэж үзлээ.

Зорилго: SARS-CoV-2 халдварын улмаас эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн тухайн үеийн сэтгэцийн эрүүл мэндийн зарим байдал, сэтгэцийн эрүүл мэндийн тусламжийн хэрэгцээг судлан тогтооход оршино.

Арга, аргачлал: Судалгааг дескриптив судалгааны эмнэлэгт суурилсан агшингийн загвараар, асуумж судалгааны аргаар хийж гүйцэтгэв. Судалгаанд 2021 оны 5-8-р сард АШУҮИС-ийн Төв эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн 399 эмчлүүлэгчийг сайн дурын үндсэн дээр хамруулав. Судалгаанд судалгааны зорилго, зорилтын хүрээнд боловсруулсан 4 бүлэг 172 асуумж, никотины хамаарлын түвшинг тогтоох сорил, авир араншинг тодорхойлох сорил, ялгаварлан гадуурхалтыг үнэлэх асуумж, сэтгэл гутрал, сэтгэл түгшилтийн түвшинг үнэлэх сорилуудыг ашигласан. Статистик боловсруулалтыг STATA 15.1 программаар тооцоолсон.


Судалгааны ажлын ёс зүй: Судалгааны ёс зүйн асуудлыг Эрүүл мэндийн яамны Анагаах ухааны ёс зүйн хяналтын хорооны хурлаар хэлэлцүүлж судалгаа хийх ёс зүй зөвшөөрөл авсан (2020 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн хурлын тогтоол, дугаар (№2021/3-08) ба судалгаанд хамрагдагсдад таниулсан зөвшөөрлийн хуудсаар дамжуулан судалгаанд оролцох зөвшөөрөл авч гарын үсгээр баталгаажуулан судалгааны картанд хавсаргасан болно.

Үр дүн: Бидний судалгаанд 18-85 насны 399 эмчлүүлэгч хамрагдсан ба дундаж нас нь 40.5±0.7 жил, 56% нь эмэгтэй (n=224) байсан ба эмэгтэй, эрэгтэй хүйсийн харьцаа 1.28:1 байв. Эмчлүүлэгсэд нь судалгаанд хамрагдах үедээ эмчилгээний 1-12 дахь хоногтоо эмчлүүлж байсан ба дундаж ор хоног 8.4±0.9 байлаа.

Хүснэгт 1. Хүн ам зүйн ерөнхий үзүүлэлт (хувиар)

Нас	18-30	31-40	41-50	51-60	>61	Нийт	p утга
Хүйс							
Эрэгтэй	25	23.5	25	19	7.50	44%	p=0.09
Эмэгтэй	33	23.0	18	14	11.50	56%	
Боловсролын түвшин							
Дээд	35	31	19	9	6	48%	
Бүрэн дунд	32	19	24	16	9	35%	p=0.001
Бусад	10.5	10.5	22	36	21	17%	
Гэрлэлтийн байдал							
Гэр бүлтэй	17	27.5	26	20	9.5	100%	
Гэр бүл болоогүй	81	9.5	8	-	1.5	100%	p =0.001
Бусад	24	22	16	17	21	100%	
Хэн хэнтэйгээ амьдардаг болох							
Эхнэр, нөхөр хүүхдийн хамт	15	28	25.5	20	11.5	71%	
Аав, ээжийн хамт	77	12	8	3	-	17%	p =0.001
Бусад	52	10.5	12.5	12.5	12.5	12%	
Ажил эрхлэлт							
Улсын байгууллагад ажилладаг	31	24	31	14	-	20%	
Хувийн байгууллагад ажилладаг	34	36	16	10	4	28%	p=0.001
Хувиараа ажил эрхэлдэг	15	27.5	37	19	1.5	18%	
Ажил эрхэлдэггүй	33	11	10	21	25	34%	
N	118	94	84	64	39	399	
%	30	24	21	16	10	100	

Хүснэгт 1-ээс харахад хүйсийн хувьд эмэгтэйчүүд илүү өвдсөн байгаа хэдий ч өвчлөгсдийн хүйсийн хувьд статистик ач холбогдолгүй (p=0.09), харин насны бүлгээр 18-40 насныхан хамгийн их буюу 53%-ийг эзэлж байна. Харин SARS-C V-2 халдвараар өвчлөгсөд нь боловсролын түвшин (p<0.001), гэрлэлтийн байдал (p<0.001), ажил эрхлэлтийн байдлаараа (p<0.001) статистикийн хувьд ач холбогдол бүхий ялгаатай байв. Бид эмчлүүлэгсдийн сэтгэцийн эрүүл мэндийн зарим байдлыг судлан тогтоож байгаа учир судалгаанд хамрагдагсдын авир араншинг Айзенкийн сорилоор тодорхойлов. (Зураг 1)



Зураг 1. Эмчлүүлэгчдийн авир араншин (хувиар)

Сорилын дүнг 1-р зургаас үзвэл сангвиник хэв шинж илүү буюу 35.5% (n=141)-ийг эзэлж байгаа бол флегматик (n=105, 26.5%), холерик (n=101, 25%) хэвшинж ойролцоо үзүүлэлтэй, меланхолик хэв шинж (n=52,13%) бага хувийг тус тус эзэлж байв.


Бид судалгаанд оролцогчдын сэтгэцийн эрүүл мэндийн байдлыг судлан үзвэл нийт оролцогчдын 98.2%-д (n=392) нь нийгмийн ялгаварлан гадуурхалд, 97.5%-д (n=389) нь өөрийгөө ялгаварлан гадуурхалд өртсөн хэмээн хариулсан ба 52.4%-д (n=209) сэтгэл гутрал, 79.6%-д (n=318) сэтгэл түгшил, 6.1%-д (n=24) нь гэмтлийн дараах стрессийн эмгэг, 48.6%-д (n=194) нойрны хямрал тус тус илэрсэн байна.

Хүснэгт 2. Сэтгэцийн эрүүл мэндийн байдлыг хүн ам зүйн үзүүлэлтээр харьцуулсан байдал (хувиар)

Үзүүлэлтүүд	Нийт		Сэтгэл гутрал илэрсэн	Сэтгэл түгшилт илэрсэн	Гэмтлийн дараах стрессийн эмгэг илэрсэн	Нойрны хямрал илэрсэн
Хүйс						
Эрэгтэй	175	44%	43.4% (76)	76% (133)	3.4% (6)	48.6% (85)
Эмэгтэй	224	56%	59.4% (133)	82.6% (185)	8% (18)	48.7% (109)
Нийт	**399**	**100%**	**52.4% (209)**	**79.6 % (318)**	**6.1% (24)**	**48.6 % (194)**
Насны бүлэг						
18-30	118	30%	61.9% (73)	83% (98)	4.2% (5)	50.9% (60)
31-40	94	24%	54.3% (51)	77.7% (73)	7.5% (7)	46.8% (44)
41-50	84	21%	42.9% (36)	79.8% (67)	9.5% (8)	50% (42)
51-60	64	16%	43.8% (28)	81.2% (52)	3.1% (2)	45.3% (29)
61-ээс дээш	39	10%	53.9% (21)	71.8% (28)	5.1% (2)	48.7% (19)
Боловсролын түвшин						
Дээд	193	48%	55.4% (107)	85% (164)	6.7% (13)	56.5% (109)
Бүрэн дунд	139	35%	50.4% (70)	74.1% (103)	5% (7)	43.2% (60)
Бусад	67	17%	47.8% (32)	76.1% (51)	6% (4)	37.3% (25)
Сэтгэлзүйн хэвшинж						
Меланхолик	52	13%	69.2% (36)	94.2% (49)	9.6% (5)	63.5% (33)
Холерик	101	25%	77.2% (78)	93.1% (94)	12.9% (13)	66.3% (67)
Сангвиник	141	36%	37.6% (53)	71.6% (101)	1.4% (2)	39.7% (56)
Флегматик	105	27%	40% (42)	70.5% (74)	3.8% (4)	36.2% (38)


Хоёрдугаар хүснэгтээс харвал эмэгтэйчүүдэд сэтгэл гутрал, сэтгэл түгшилт, гэмтлийн дараах стрессийн эмгэг илүү, харин нойрны хямрал нь хүйсийн хувьд ойролцоо үзүүлэлттэй байна. (Зураг 2) Насны бүлгээр үзвэл аль ч насны бүлэгт сэтгэл түгшилт илүүтэй илэрсэн бөгөөд харин боловсролын хувьд дээд боловсролтой хүмүүст сэтгэл гутрал, сэтгэл түгшилт (n=164; p=0.038), гэмтлийн дараах стрессийн эмгэг, нойрны хямрал зэрэг сэтгэцийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлууд нь бүгд боловсролын бусад түвшингээс илүүтэй буюу 6.7-85%-д илэрсэн байв.

Нойрны хямрал нь хүйсийн хувьд ойролцоо үзүүлэлттэй байгаа хэдий ч 18-30 насны бүлэгт (50.9%), дээд боловсролтой (56.5%, p=0.007), холерик хэвшинжийн хүмүүст илүүтэй илэрсэн нь статистик ач холбогдол бүхий ялгаатай (n=67; p=0.0001) байв.



Зураг 2. Эмчлүүлэгчдийн сэтгэцийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлыг хүйсээр харьцуулсан байдал (бодит тоогоор)

Бид дээр дурдсанчлан сэтгэцийн эрүүл мэндийн тулгамдсан асуудал илэрсэн нийт эмчлүүлэгчдийг сэтгэл зүйн хэв шинж тус бүрээр нь харьцуулан үзэхэд аль ч сэтгэцийн тулгамдсан асуудал нь меланхолик болон холерик хэв шинжтэй хүмүүст илүүтэй илэрсэн. (Зураг 3)



Зураг 3. Эмчлүүлэгчдийн сэтгэцийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлын түвшинг хувь хүний сэтгэл зүйн хэв шинжээр харьцуулсан байдал (хувиар)

Хүснэгт 3. Сэтгэцийн эрүүл мэндийн тулгамдсан асуудалтай эмчлүүлэгчид сэтгэцийн эрүүл мэндийн зөвлөгөө, дэмжлэгийн хэрэгцээг тодорхойлсон байдал

Сэтгэцийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлууд	Нийт илрэл (бодит тоогоор)	"Ковид өвчнөөр өвчилсөн хүмүүст сэтгэцийн эрүүл мэндийн зөвлөгөө, дэмжлэг хэрэгтэй юу?" гэсэн асуултын хариу (бодит тоо; хувь)		
		Хэрэгтэй	Мэдэхгүй	Хэрэггүй
	399 (N)	276 (69%)	34 (9%)	89 (22%)
Гэмтлийн дараах стрессийн эмгэг	24	21 (87.5%)	0 (0%)	3 (12.5%)
Нойрны хямрал	194	134 (69%)	16 (8%)	44 (23%)
Сэтгэл гутрал	209	152 (73%)	14 (7%)	43 (20%)
Сэтгэл түгшилт	318	221 (69.5%)	24 (7.5%)	73 (23%)
Нийгмийн ялгаварлан гадуурхалт	392	272 (69.5%)	33 (8.5%)	87 (22%)
Өөрийгөө ялгаварлан гадуурхах	389	269 (69%)	34 (9%)	86 (22%)

Бид нийт судалгаанд оролцогчдоос (n=399) "Ковид өвчнөөр өвчилсөн хүмүүст сэтгэцийн эрүүл мэндийн зөвлөгөө, дэмжлэг хэрэгтэй юу?" гэсэн асуултанд хариулсан байдлыг судлан үзвэл дийлэнх хувь нь буюу 69% (n=276) нь хэрэгтэй гэж хариулсан бол 22% нь хэрэггүй хэмээн хариулсан байлаа. Сэтгэцийн эрүүл мэндийн тулгамдсан асуудал илэрсэн эмчлүүлэгчдийн дийлэнх (69-87.5%) нь сэтгэцийн эрүүл мэндийн зөвлөгөө, дэмжлэг хэрэгтэй гэж хариулсан боловч бусад бүлгүүдтэй харьцуулахад статистик ач холбогдол бүхий ялгаа ажиглагдсангүй.

Бид судалгаанд ашигласан сорилын чанарыг Кронбахын коэффициентоор тооцож үзэхэд нийгмийн ялгаварлан гадуурхлыг үнэлэх сорил α=0.90, өөрийгөө дорд үзэх байдлыг үнэлэх сорил α=0.89, хувь хүний сэтгэлзүйн хэв шинжийг тодорхойлох-EPI сорил α=0.81 байв.

Хэлцэмж: SARS-CoV-2 цар тахлын тархалт нэмэгдэх тусам сэтгэцийн эрүүл мэндэд үзүүлэх урт хугацааны нөлөө нь тодорхойгүй хэвээр байна.

Бидний судалгаагаар SARS-CoV-2 халдварын улмаас үүссэн сэтгэл гутрал нь эрэгтэйчүүдийн 43.4%-д харин эмэгтэйчүүдийн хувьд илүү өндөр 59.4%-д илэрсэн нь Argüder E нарын (2020) Туркын Анкара хотод хийсэн судалгаанд эрэгтэйчүүдийн 6.5%-д, эмэгтэйчүүдийн 11.3%-д илэрсэнтэй болон Beutel, M. E. нарын (2021) Герман улсад хийсэн судалгаанд эрэгтэйчүүдийн 9.8%-д, эмэгтэйчүүдийн 13.3%-д илэрсэн үзүүлэлтүүдтэй ойролцоо байна.[7,8] Мөн Dovbysh D нарын (2021) Орос улсад хийсэн судалгаанд оролцогчдод сэтгэл гутрал 25.4%-д илэрсэн ба сэтгэл гутралын дундаж хувь эмэгтэйчүүдэд 8.76, эрэгтэйчүүдэд 6.32 буюу эмэгтэйчүүдэд сэтгэл гутрал илүүтэй илэрсэн байгаа нь манай судалгааны дүнтэй болон хэд хэдэн орны судалгааны үзүүлэлттэй дүйж байна.[9]

Argüder E нарын (2020) SARS-CoV-2 халдварын улмаас эмнэлэгт хэвтэн эмчлүүлж буй 300 (115 эмэгтэй, 185 эрэгтэй) эмчлүүлэгчдийг хамруулан хийсэн судалгаагаар сэтгэл түгшилт эрэгтэйчүүдэд 2.7%, эмэгтэйчүүдэд 15.7% тодорхойлогдсон нь манай судалгааны үр дүнд эрэгтэйчүүдэд 76%, эмэгтэйчүүдэд илүү өндөр түвшинд буюу 82.6% илэрсэнтэй ойролцоо байв.[7] Мөн Tokur K нарын (2021) Туркийн баруун хойд хэсэгт орших хотод хийсэн судалгаанд эрэгтэйчүүдийн сэтгэл түгшилтийн дундаж оноо 2, эмэгтэйчүүдийнх 8 буюу өндөр түвшинд илэрсэн нь манай судалгааны үр дүнтэй дүйж байна. Tokur K нар (2021) сэтгэл түгшилт эмэгтэйчүүдэд эрэгтэйчүүдийнхээс өндөр үзүүлэлттэй илэрсэн шалтгааныг жендерийн үүрэгтэй холбоотой буюу өөрөөр хэлбэл эмэгтэйчүүд гэр ахуйн хүрээний цэвэрлэгээ үйлчилгээнд илүүтэй оролцдог бөгөөд цар тахлын үед энэхүү үүрэг нь ихээхэн нэмэгдэж, улмаар эмэгтэйчүүдийн сэтгэл түгшилтийн түвшинг нэмэгдүүлсэн гэж тайлбарласан ба энэ нь манай орны хувьд ч байж болох талтай учир цаашид нарийвчлан судалж үзэх шаардлагатай байна.[10]

Манай судалгааны нэгэн адил сэтгэл гутралын түвшинг PHQ-9, сэтгэл түгшилтийг GAD-7, нойргүйдлийг ISI сорил ашиглан хийсэн Chengmin W нарын (2021) Хятад улсын Шенжэнь хотод хийсэн судалгаагаар коллеж ба түүнээс дээш боловсролтой оролцогчдын 62.2%-д сэтгэл гутрал, сэтгэл түгшилт, нойргүйдэл бусад бүлгүүдтэй харьцуулахад өндөр түвшинд илэрсэн нь манай судалгааны үр дүнтэй буюу дээд боловсролтой судалгаанд оролцогчдын бүлэгт сэтгэл гутрал 55.4%-д, сэтгэл түгшилт 85%-д, нойргүйдэл 56.5%-д илэрсэнтэй дүйж байна.[11] Мөн Lei, L нарын (2020) судалгаагаар боловсролын түвшин доогуур хүмүүсийн сэтгэл түгшилтийн түвшин бага, өндөр боловсролтой хүмүүсийн сэтгэл түгшилтийн түвшин өндөр байсан.[12] Энэхүү үр дүн нь бидний судалгаатай ойролцоо байгаа бөгөөд SARS-CoV-2 -ийн шинж тэмдгүүдийн талаар илүү их мэдлэгтэй байх нь хүн амын сэтгэл түгшилтийн түвшинг нэмэгдүүлж байх магадлалтай гэж таамаглаж байна.

Nirmita P нарын (2021 он) Америк улсад хийсэн судалгаагаар цар тахлын үед 18-24 насны залуучуудын 56%-д нь сэтгэл түгшилт эсвэл сэтгэл гутралын шинж тэмдэг илэрч байсан нь сэтгэцийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлууд залуу насанд илүү өндөр байгааг илэрхийлэх үзүүлэлт бөгөөд бидний судалгааны үр дүнд 18-30 насныхны дунд сэтгэл гутрал 61.9%-д, сэтгэл түгшилт 83%-д илэрсэнтэй ойролцоо байна. Мөн энэ залуучуудад сэтгэцийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлууд илүүтэй илэрч байгаа шалтгааныг цар тахлын үед сургууль, олон нийтийн газрууд хаагдаж, орлого буурсантай холбоотойгоор тэдний сэтгэцийн эрүүл мэндийн байдалд хор уршиг учруулсан хэмээн

тайлбарласан нь манай орны хувьд ч мөн адил хорио цээрийн дэглэмд дээрх асуудлууд үүсэж байсантай холбоотой байж болох юм.[13]

Srinivasan S нар (2022) Энэтхэгийн нүдний эмнэлэгт хандан тусламж үйлчилгээ авсан 546 хүнд хувь хүний авир араншин, сэтгэл түгшилтийн харилцан хамаарлыг судлан үзэхэд 17% нь «Холерик», 26% нь "Меланхолик», 28% нь "Флегматик», 27% нь "Сангвиник» авир араншинтай байсан бөгөөд хувь хүний авир араншин нь сэтгэл түгшилтийг нэмэгдүүлэхэд нөлөөлдөг боловч статистик ач холбогдол бага гэж тодорхойлжээ.[14] Манай судалгааны хувьд авир араншин болон сэтгэл түгшилтийн илрэлийг харьцуулан үзэхэд "Меланхолик" авир араншинтай оролцогчдын 94.2%-д, "Холерик" оролцогчдын 93.1%-д, "Сангвиник" оролцогчдын 71.6%-д, "Флегматик" оролцогчдын 70.5%-д сэтгэл түгшилт илэрсэн буюу аль ч хэв шинжийн хүмүүст ямар нэгэн хэмжээгээр сэтгэл түгшилт илэрч байгаа нь дээрх судалгаатай ойролцоо үр дүнтэй байв. Харин статистик ач холбогдол бүхий ялгаа их байсан.

Олон орны судлаачид SARS-CoV-2 халдварын дэгдэлтийн эхний үе шатанд байгаа өвчтөнүүдэд сэтгэц эмгэгийн олон шинжүүд илэрсэн ба ялангуяа сэтгэлийн гэмтлийн дараах стрессийн эмгэгийн шинжүүд өндөр түвшинд байгааг мэдээлсээр байна. Бид дэлхий дахинаа урьд нь тархаж байсан цар тахлын үеийн хүн амын сэтгэл зүйн байдлыг судлан үзэхэд SARS-ийн дэгдэлтийн үеэр сэтгэцийн эрүүл мэндэд үзүүлэх сөрөг үр дагавар нь халдварын дэгдэлттэй харьцуулахад шууд илрэл багатай, харин урт хугацааны дараа илэрч байсан гэж дүгнэсэн[1,2,15,16] ба Lee AM нарын (2007) судалгаагаар SARS-өвчнөөр өвчлөөд амьд үлдсэн хүмүүсийн сэтгэл зүйн хямрал нь өвчин дэгдсэнээс хойш нэг жилийн дараа 64% -д хүрсэн байна.[15] Энэхүү үр дүнгээс үзвэл SARS-CoV-2 цар тахлын дараах сэтгэцийн эрүүл мэндэд үзүүлэх нөлөө нь хүлээгдэж байхыг үгүйсгэх аргагүй юм. Мөн Wu KK нарын (2003) амьсгалын замын цочмог хам шинж (SARS) дэгдсэний дараа уг халдвараар өвчлөөд амьд үлдсэн хүмүүст сэтгэлийн гэмтлийн дараах стрессийн эмгэгийн тархалт өвчний эрт үед 9.79% байсан бол 30 сарын дараах үнэлгээгээр 25.6% болж ихсэж байжээ.[3] Бидний судалгаагаар сэтгэлийн гэмтлийн дараах стрессийн эмгэг шинжүүд 6%-д илэрч байгаа боловч урт хугацааны дараа өсөн нэмэгдэж болох магадлалтай гэж үзэж байна. Тиймээс, SARS-CoV-2 -д нэрвэгдсэн өвчтөнүүдийн сэтгэлийн гэмтлийн дараах стрессийн эмгэг нь SARS-ын улмаас үүссэн гэмтлийн дараах стрессийн эмгэгээс ч илүү байхыг үгүйсгэхгүй учир цаашид дагах судалгаа хийх шаардлагатай байна гэж үзэж байна.

Gubler DA нарын (2021) Швейцарт хийсэн судалгаанд SARS-CoV-2 -той холбоотой нийгмээс тусгаарлах хязгаарлалтын 6 долоо хоногийн туршид мэдрэлийн эмгэг, гадагшаа чиглэсэн сэтгэлзүйн хэв шинж, сэтгэл хөдлөлөө удирдах чадварыг нь ганцаардал, сайн сайхан байдалтай хэрхэн холбогдож буйг судалсан байдаг. Судалгааны үр дүнгээс үзвэл сульдамтгай хэвшинжийн хүмүүс хүнд хэцүү нөхцөл байдалд айдас, түгшүүрээр хариу үйлдэл үзүүлдэг, илүү мэдрэмтгий, ойр дотны хүмүүс хоорондын харилцааны доголдолтой байсан байна. Иймээс гадагшаа чиглэсэн сэтгэлзүйн хэвшинжтэй хүмүүс цар тахлын үед ердийн үеийнхээс илүү их ачаалалтай, ганцаардмал мэдрэмж төрдөг, биеэ авч яваа байдал, сэтгэл зүйн сайн сайхан байдлын хоорондын хамаарал буурсан байжээ.[17]

Бидний судалгаагаар ялгаварлан гадуурхалт өндөр түвшинд илэрсэн нь Liu D нарын (2020) судалгаанд SARS-CoV-2 -ийн үе дэх хүн амын сэтгэл санааны таатай нөлөөллийг нэмэгдүүлэхэд нийгмийн гутаан доромжлол, ялгаварлан гадуурхал нь хамааралтай байсан ба олон хүчин зүйлийн логистикийн регрессийн аргаар тооцон үзэхэд ялгаварлан гадуурхах нь сэтгэлийн гэмтлийн дараах стрессийн эмгэг, сэтгэлийн хямрал, хүнд хэлбэрийн сэтгэл түгшилт үүсгэхэд нөлөөлөх эмнэлзүйн ач холбогдолтой болохыг харуулсан дүнтэй дүйж байгаа юм.[18] Тиймээс ч бидний судалгаанд оролцогчдын ихэнх хувь нь буюу 69% нь сэтгэцийн эрүүл мэндийн дэмжлэг, зөвлөгөө хэрэгтэй байна гэсэн хариулт өгсөн гэж үзэж байна. Бид цаашид цар тахлын сэтгэц, нийгэмд үзүүлэх нөлөөллийг нарийвчлан судалснаар хүн амын сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, шаардлагатай тусламж үйлчилгээ үзүүлэх боломжийг бүрдүүлэх ач холбогдолтой юм.

Дүгнэлт: SARS-CoV-2 өвчний улмаас хэвтэн эмчлүүлэгчдийн дийлэнх нь сэтгэл гутрал, сэтгэл түгшилт, нойрны хямрал, нийгмийн болон өөрийгөө ялгаварлан гадуурхах зэрэг сэтгэцийн эрүүл мэндийн тулгамдсан асуудалтай байгаа тул сэтгэл зүйн зөвлөгөө, дэмжлэг хэрэгтэй байна.

Ном зүй:

1. *Lancee WJ, Maunder RG, Goldbloom DS, Coauthors for the Impact of SS. Prevalence of psychiatric disorders among Toronto hospital workers one to two years after the SARS outbreak. Psychiatr Serv. 2008;59(1):91-95.*
2. *Mak IW, Chu CM, Pan PC, Yiu MG, Chan VL. Long-term psychiatric morbidities among SARS survivors. Gen Hosp Psychiatry. 2009;31(4):318-326.*
3. *Wu KK, Chan SK, Ma TM. Posttraumatic stress after SARS. Emerg Infect Dis. 2005;11(8):1297-1300.*
4. *Dovbysh DK, M.. Emotional response to illness in patients hospitalized with COVID-19 in russia. European Psychiatry. 2021;64(S1):S99-S100.*
5. *Flowers KM, Colebaugh CA, Hruschak V, et al. Introversion, Extraversion, and Worsening of Chronic Pain Impact during Social Isolation: A Mediation Analysis. J Clin Psychol Med Settings. 2022. Sep 8:1–12.*
6. *Wijngaards I, Sisouw de Zilwa SCM, Burger MJ. Extraversion Moderates the Relationship Between the Stringency of COVID-19 Protective Measures and Depressive Symptoms. Front Psychol. 2020;11:568907.*
7. *Emine Argüder1 HK, Musa Civak2, Ayşegül Karalezli1. ANXIETY AND DEPRESSION LEVELS IN HOSPITALIZED PATIENTS DUE TO COVID-19 INFECTION. Ankara Medical journal. 2020;Ankara Med J, 2020;(4):971-981:12.*
8. *Beutel ME, Hettich N, Ernst M, Schmutzer G, Tibubos AN, Braehler E. Mental health and loneliness in the German general population during the COVID-19 pandemic compared to a representative pre-pandemic assessment. Sci Rep. 2021;11(1):14946.*
9. *D. Dovbysh MK. Emotional response to illness in patients hospitalized with COVID-19 in russia. European Psychiatry. 2021;64(S1) (S99-S100).*
10. *Tokur Kesgin M, Hancer Tok H, Uzun LN, Pehlivan S. Comparison*

of anxiety levels of hospitalized COVID-19 patients, individuals under quarantine, and individuals in society. Perspect Psychiatr Care. 2022;58(1):149-158.
11. Wang C, Song W, Hu X, et al. Depressive, anxiety, and insomnia symptoms between population in quarantine and general population during the COVID-19 pandemic: a case-controlled study. BMC Psychiatry. 2021;21(1):99.
12. Lei L, Huang X, Zhang S, Yang J, Yang L, Xu M. Comparison of Prevalence and Associated Factors of Anxiety and Depression Among People Affected by versus People Unaffected by Quarantine During the COVID-19 Epidemic in Southwestern China. Med Sci Monit. 2020;26:e924609.
13. Nirmita Panchal RK, Cynthia Cox, Rachel Garfield. The Implications of COVID-19 for Mental Health and Substance Use. KAISER FAMILY FOUNDATION. 2021.
14. Sanjay S, Venkatesh R, Tejwani S, et al. Psychosocial assessment among ophthalmic patients attending tertiary eye care centre during the lockdown in times of COVID-19 pandemic. Indian J Ophthalmol. 2022;70(5):1767-1772.
15. Lee AM, Wong JG, McAlonan GM, et al. Stress and psychological distress among SARS survivors 1 year after the outbreak. Can J Psychiatry. 2007;52(4):233-240.
16. Chen R, Chou KR, Huang YJ, Wang TS, Liu SY, Ho LY. Effects of a SARS prevention programme in Taiwan on nursing staff's anxiety, depression and sleep quality: a longitudinal survey. Int J Nurs Stud. 2006;43(2):215-225.
17. Gubler DA, Makowski LM, Troche SJ, Schlegel K. Loneliness and Well-Being During the Covid-19 Pandemic: Associations with Personality and Emotion Regulation. J Happiness Stud. 2021;22(5):2323-2342.
18. Liu D, Baumeister RF, Veilleux JC, et al. Risk factors associated with mental illness in hospital discharged patients infected with COVID-19 in Wuhan, China. Psychiatry Res. 2020;292:113297.

The results of the study of the mental health care needs of patients admitted to the Central Hospital of MNUMS due to SARS-CoV-2 infection

Mongoljin A[1,2], Munkh E[1,2], Altaisaikhan KH[3], Hishigsuren Z[1]

[1]School of Medicine, MNUMS
[2]National Center for Mental Health
[3] University of Central Hospital, MNUMS
E-mail: am.mongoljin@gmail.com, Tel:+976-80039666

Background: The rapid global spread of SARS-CoV-2 to pandemic proportions has increased the public's awareness of the importance of mental health care and needs. In other words, the pandemic had seriously impacted the well-being of the population's psychology and mental health. In particular, patients hospitalized with confirmed SARS-CoV-2 infection are more likely to suffer from depression and sleep disturbances due to fear of long-term consequences of the infection, fear of spreading the infection to others, fear of death, social discrimination, depression, and in some cases suicide attempts, mentioned the risk of suicide. Therefore, we believe that it is necessary to study some of the mental health conditions and mental health care needs of patient admitted to the MNUMS hospital with SARS-CoV-2 confirmed

Aim: To determine the mental health some status and mental health care needs of hospitalized patient due to SARS-CoV-2 infection.

Materials and Methods: The study was carried out using a descriptive research hospital-based snapshot model and a questionnaire survey method. In the study, 399 inpatients admitted to University of Central Hospital, MNUMS between May and August 2021 were included in the study voluntarily. Statistical treatment was calculated using STATA 15.1 software.

Research Ethics: The research work was discussed at the Ethical Review Committee of the Ministry of Health meeting on 18.06.2020, and ethical approval for the research was obtained (#2021/3-08).

Results: Our study included 399 patients aged 18-85 with an average age of 40.5±0.7. 56% of the respondents were female (n=224), with a gender ratio of 1.28:1. At the time of the study, patients were still hospitalized for 1-12 days, and the average length of hospitalization was 8.4±0.9. According to the results of the study, 52.4% (n=209) had depression, 80% (n=318) had anxiety, 49% (n=194) had sleep disorders, and 6% (n=24) had post-traumatic stress disorder, 98% (n=392) experienced social discrimination, and 97.5% (n=389) experienced self-discrimination. When the reliability of the test for assessing the level of discrimination was calculated by Cronbach's coefficient, the test for assessing social discrimination was α=0.90, and the test for assessing self-discrimination was α=0.89. Also, the reliability of the personality trait EPI test used in the study was α=0.81.

The majority of the respondents 69% (n=276) answered "It is necessary" to the question "Do people with Covid-19 need mental health advice and support?". The majority of patients with mental health problems believed that people with covid needed mental health counseling and support, but no statistically significant differences were observed compared to other groups.

Conclusion: The majority of hospitalized patients had mental health problems such as depression, anxiety, sleep disorders, and social and self-discrimination, and 69% of the patients answered that they needed help, indicating that patients need mental health counseling and support.

Keywords: Epidemic, Mental health, Needs, Care